



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 70007734, Факс: (976-11) 32 01 54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2019.02.25 № 572

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ,  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Д.БАТСҮХ ТАНАА

Нийслэлийн Аялал, жуулчлалын газрын 2018  
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан,  
гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 23 хуудас.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  С.ЭНХБААТАР



D:\2019 onlYwuulsan bichig\2019.02.25 N-AJG.docx A5  
1110400542



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 70007734, Факс: (976-11) 32 01 54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2019.02.25 № 543

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



С.ЭНХБААТАР

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2019/510/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2019 он

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Ц.Бат-Өлзий

Утас: 327734

Цахим хаяг: bat-ulziits@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цогбаяр

Утас: 315558

Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn

Аудитор:

Ц.Батсүх

Утас: 325093

Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


## Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	15

## 1 Аудитын гэрчилгээ

	<b>НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Д.БАТСҮХ ТАНАА</b>
<b>ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b>	
<p>14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар, Утас: 70007734, Факс: (976-11) 32 01 54, E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn</p>	
<p>2019.02.25 № 543</p>	
танай _____	-ны № _____
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b><u>Зөрчилгүй санал дүгнэлт</u></b>	
<p>Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<small>D:\2019 on\Ywulsan bichig\2019.02.25.N-AJG.docx</small>	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



С.ЭНХБААТАР



## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын дарга Д.Батсүхэд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 28-наас 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, НТАГ-ын аудитор Ц.Батсүх хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг НТАГ-т 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 01/36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь *“Нийслэл Улаанбаатар хотыг гадаадын жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ”* гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: *“Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох, жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх, жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах, нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх”* гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Аялал жуулчлалын тухай хууль
- “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа гол хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах Шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Accolos” программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Нийслэлийн Аялал жуулчлалын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод

хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь зардлыг буруу илэрхийлэх, орхигдуулах магадлал ихтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны нийт зардал 1,293,746.0 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 25,874.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	9,894.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	3	9,894.9	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан болно.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй, аялал жуулчлалын чиглэлээр гадаад улс оронд зохион байгуулж буй үйл ажиллагаатай холбоотой гарч буй зардлууд тухайн улсад орлого орж буй боловч өөрийн оронд зохион байгуулж буй ижил төстэй арга хэмжээний орлого, зардалтай уялдахгүй байгаа нь анхаарал татаж байна. Эдгээр нь аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад түүвэрт хамруулан шалгаж амжаагүй дээрх асуудлыг 2019 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 2 арга хэмжээнд зориулан 2018 онд 238,370.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 236,428.3 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь 1,942.5 мянган төгрөгөөр төсвийг дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 236,428.4 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь үндсэн цалинг 1,352.3 мянган төгрөгөөр хангамж, бараа материал 562.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлаас 27.4 төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Тус хэлтсийн төсвийн захирагч нь 2018 онд улсын төсвөөс 238,370.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдсаныг бүрэн авч, үйл ажиллагааны урсгал зардалд 236,428.4 мянган төгрөг зарцуулж, төсвийн үлдэгдэл 7,289.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс туслах үйл ажиллагааны орлогоос 5,347.0 мянган төгрөг, төсвөөс 1,942.5 мянган төгрөг тус тус төвлөрүүлсэн.

Нэмэлт санхүүжилтийн дансаар НЗДТГ-аас 989,170.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 11,240.7 мянган төгрөгийг өөрийн орлогоор бүрдүүлэн зарцуулжээ.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Нийслэлийн Аялал жуулчлалын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

**Үйлчлүүлэгч байгууллагын хариу:**



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР


Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
Ж.Самбуугийн гудамж, Бага тойруу 15,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: 7012-8687  
E-mail: info@tourism.ub.gov.mn  
http://www.tourism.ub.gov.mn

2019-02-22 № 01/80  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

Асуудлын бүртгэлтэй танилцаж санхүүгийн байдлын тайланд алдаатай тайлагнасанийг залруулга хийж тайланг хөргүүлэв. Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу үйл ажиллагаагаа сайжруулан явуулах болно. Нийслэлийн Засаг даргын А/147, А/234 тоот захирамжийн гадаад улсад зохион байгуулагдсан арга хэмжээний талбайн түрээсийн төлбөрийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байсныг нэмэлтээр баримт хөргүүлсэн болно.

ДАРГА *D. Balmaa* Д.БАТСҮХ



1150500069

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийслэлийн Аялал жуулчлалын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

- Өмнөх оны 12.5 мянган төгрөгийн авлага, 84.7 мянган төгрөгийн өглөг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалтыг зөрчсөн.

##### **3.1.2 Эрсдэл:**

- Санхүүгийн үр дүнгийн тайлан тооцооллын хувьд алдаатай байх авлага, өглөг барагдуулаагүй байх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

- Өмнөх оны авлага, өглөгийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.



### **3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

- Гадаад улсад зохион байгуулсан арга хэмжээний түрээсийн төлбөрт анхан шатны бүрдэл дутуу баримтаар 9,706.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” заалтыг зөрчсөн.

#### **3.2.2 Эрсдэл:**

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийх;

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

- Гадаад улсад зохион байгуулсан арга хэмжээний удирдамжийг үндэслэн төсөв зохиож батлуулж байх;

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

### **3.3 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

- Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн анхан шатны баримтаас 91.7 мянган төгрөгөөр зөрүүтэй. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.”Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна” заалтыг зөрчсөн.

#### **3.3.2 Эрсдэл:**

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийх;

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

- Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн анхан шатны баримтыг үндэслэж залруулга хийж байх;

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

## АУДИТЫН ТАЙЛАНГ


### Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга бөгөөд  
аудитын менежер

Аудитын менежер

### Бэлтгэсэн:

Аудитор

  
Ц.Бат-Өлзий  
А.Цогбаяр  
Ц.Батсүх

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>130 709 974.00</b>	<b>97 717 302.84</b>
<b>АВЛАГА</b>	12 516.00	33 983.84
Бусад авлага	12 516.00	33 983.84
Байгууллагаас авах авлага	-	21 467.84
Хувь хүмүүсээс авах авлага	12 516.00	12 516.00
<b>УРЬДЧИЛГАА</b>	45 995 676.00	-
Урьдчилж гарсан зардал	45 995 676.00	-
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	84 701 782.00	97 683 319.00
<b>Түүхий эд материал</b>	-	37 788 050.00
Тусгай зориулалттай материал	-	37 788 050.00
<b>Хангамжийн материал</b>	84 701 782.00	59 895 269.00
Бичиг хэргийн материал	7 312 131.00	6 291 743.00
Аж ахуйн материал	2 789 895.00	2 816 395.00
Сэлбэг хэрэгсэл	270 100.00	250 100.00
Түлш, шатах тослох материал	-	3 356 800.00
Бусад хангамжийн материал	74 329 656.00	47 180 231.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>49 180 305.79</b>	<b>33 020 651.45</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	49 180 305.79	33 020 651.45
<b>Биет хөрөнгө</b>	25 085 805.79	15 074 651.45
Машин тоног төхөөрөмж (компьютер)	51 982 566.00	51 982 566.00
Хуримтлагдсан элэгдэл	(38 616 341.81)	(44 225 589.19)
Тавилга, аж ахуйн эд хогшил	32 802 800.00	32 802 800.00
Хуримтлагдсан элэгдэл	(22 538 773.88)	(25 874 014.12)
Бусад үндсэн хөрөнгө	5 000 000.00	5 000 000.00
Хуримтлагдсан элэгдэл	(3 544 444.52)	(4 611 111.24)
<b>Биет бус хөрөнгө</b>	24 094 500.00	17 946 000.00
Програм хангамж	30 834 000.00	30 834 000.00
Хуримтлагдсан элэгдэл	(6 739 500.00)	(12 888 000.00)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>179 890 279.79</b>	<b>130 737 954.29</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>84 720.64</b>	<b>84 720.64</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	84 720.64	84 720.64
<b>Өглөг</b>	84 720.64	84 720.64
Ажилчидтай холбогдсон өглөг	26 283.64	26 283.64
<b>Бусад өглөг</b>	58 437.00	58 437.00
Байгууллагад төлөх өглөг	58 437.00	58 437.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>179 805 559.15</b>	<b>130 653 233.65</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	179 805 559.15	130 653 233.65
Засгийн газрын сан/орон нутгийн сан	60 000 000.00	60 000 000.00
Өмч:- төрийн	60 000 000.00	60 000 000.00
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	119 805 559.15	70 653 233.65
Өмнөх үеийн үр дүн	(5 928 687.44)	119 805 559.15
Тайлант үеийн үр дүн	125 734 246.59	(49 152 325.50)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>179 890 279.79</b>	<b>130 737 954.29</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>775 005 695.01</b>	<b>1 244 593 712.72</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого	26 190 000.00	5 716 159.83
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4 740 000.00	5 513 359.83
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21 450 000.00	202 800.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>748 815 695.01</b>	<b>1 238 877 552.89</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>530 010 395.00</b>	<b>1 000 506 652.89</b>
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй хөрөнгө	510 010 395.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20 000 000.00	989 170 332.89
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт	-	11 336 320.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт	218 805 300.01	238 370 900.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>649 250 115.09</b>	<b>1 293 746 038.22</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>649 250 115.09</b>	<b>1 293 746 038.22</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>632 099 952.92</b>	<b>1 253 807 319.58</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>179 045 204.48</b>	<b>216 485 571.14</b>
Үндсэн цалин	146 063 611.48	183 059 921.14
Нэмэгдэл	19 272 593.00	18 989 650.00
Унаа хоолны хөнгөлөлт	13 709 000.00	14 436 000.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20 935 196.00</b>	<b>27 421 381.75</b>
Тэтгэврийн даатгал	13 463 562.00	18 852 764.74
Тэтгэмжийн даатгал	1 878 783.00	2 341 295.79
ҮОМШӨ-ний даатгал	1 529 652.00	1 734 797.83
Ажилгүйдлийн даатгал	369 382.00	408 410.49
Эрүүл мэндийн даатгал	3 693 817.00	4 084 112.90
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24 349 098.00</b>	<b>17 215 517.05</b>
Бичиг хэрэг	9 537 758.00	5 285 447.00
Тээвэр, шатахуун	10 097 196.93	5 009 971.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 714 143.07	4 230 562.05
Бараа материал акталсны зардал	-	2 689 537.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>389 747 260.00</b>	<b>975 582 595.30</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	389 747 260.00	974 466 595.30
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	1 116 000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18 023 194.44</b>	<b>17 102 254.34</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	3 362 900.00	942 600.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14 660 294.44	16 159 654.34
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17 150 162.17</b>	<b>39 938 718.64</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8 460 000.00</b>	<b>24 618 800.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22 618 800.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8 460 000.00	2 000 000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	8 690 162.17	15 319 918.64
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>125 755 579.92</b>	<b>(49 152 325.50)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>21 333.33</b>	<b>-</b>
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21 333.33	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(21 333.33)</b>	<b>-</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>125 734 246.59</b>	<b>(49 152 325.50)</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>769 334 661.01</b>	<b>1 244 224 642.89</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4 740 000.00</b>	<b>5 347 090.00</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4 740 000.00	5 347 090.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>764 594 661.01</b>	<b>1 238 877 552.89</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>545 789 361.00</b>	<b>1 000 506 652.89</b>
ЗГНХ,ЗДНХхөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	525 789 361.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20 000 000.00	989 170 332.89
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11 336 320.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>218 805 300.01</b>	<b>238 370 900.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	218 805 300.01	238 370 900.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>769 074 861.01</b>	<b>1 244 224 642.89</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>769 074 861.01</b>	<b>1 244 224 642.89</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>751 924 698.84</b>	<b>1 204 285 924.25</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>165 804 264.01</b>	<b>169 785 761.31</b>
Үндсэн цалин	123 001 164.01	126 982 661.31
Нэмэгдэл	29 299 500.00	29 299 500.00
Унаа хоолны хөнгөлөлт	13 503 600.00	13 503 600.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18 294 600.00</b>	<b>20 536 600.00</b>
Тэтгэврийн даатгал	18 294 600.00	14 968 800.00
Тэтгэмжийн даатгал	-	578 400.00
ҮОМШӨ-ний даатгал	-	1 330 500.00
Ажилгүйдлийн даатгал	-	332 600.00
Эрүүл мэндийн даатгал	-	3 326 300.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16 900 000.00</b>	<b>14 814 630.05</b>
Бичиг хэрэг	6 705 660.00	5 650 097.00
Тээвэр, шатахуун	5 480 196.93	4 933 971.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 714 143.07	4 230 562.05
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр, хураамж</b>	<b>546 993 834.83</b>	<b>998 176 332.89</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	545 543 834.83	997 060 332.89
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1 450 000.00	1 116 000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3 932 000.00	972 600.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17 150 162.17</b>	<b>39 938 718.64</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8 460 000.00</b>	<b>24 618 800.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22 618 800.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8 460 000.00	2 000 000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	8 690 162.17	15 319 918.64
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>259 800.00</b>	<b>=</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>259 800.00</b>	<b>-</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	259 800.00	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(259 800.00)</b>	<b>=</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	60 000 000.00	0.00	-5 928 687.44	54 071 312.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>-5 928 687.44</b>	54 071 312.56
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	125 734 246.59	125 734 246.59
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>119 805 559.15</b>	179 805 559.15
<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>119 805 559.15</b>	179 805 559.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>119 805 559.15</b>	179 805 559.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-49 152 325.50	-49 152 325.50
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>70 653 233.65</b>	130 653 233.65

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238 370 900.00	236 428 391.36	1 942 508.64	99.19
УРСГАЛ ЗАРДАЛ	238 370 900.00	236 428 391.36	1 942 508.64	99.19
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213 752 100.00	211 809 591.36	1 942 508.64	99.09
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171 138 100.00	169 785 761.31	1 352 338.69	99.21
Үндсэн цалин	128 335 000.00	126 982 661.31	1 352 338.69	98.95
Нэмэгдэл	29 299 500.00	29 299 500.00	-	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	13 503 600.00	13 503 600.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20 536 600.00	20 536 600.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	13 883 800.00	14 968 800.00	(1 085 000.00)	107.81
Тэтгэмжийн даатгал	1 663 300.00	578 400.00	1 084 900.00	34.77
ҮОМШӨ-ний даатгал	1 330 500.00	1 330 500.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	332 600.00	332 600.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	3 326 400.00	3 326 300.00	100.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	15 377 400.00	14 814 630.05	562 769.95	96.34
Бичиг хэрэг	5 677 400.00	5 650 097.00	27 303.00	99.52
Тээвэр, шатахуун	5 000 000.00	4 933 971.00	66 029.00	98.68
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 700 000.00	4 230 562.05	469 437.95	90.01
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5 700 000.00	5 700 000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4 584 000.00	4 584 000.00	-	100.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1 116 000.00	1 116 000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1 000 000.00	972 600.00	27 400.00	97.26
Бараа үйлчилгээний бусад зардал	1 000 000.00	972 600.00	27 400.00	97.26
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24 618 800.00	24 618 800.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	24 618 800.00	24 618 800.00	-	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22 618 800.00	22 618 800.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 000 000.00	2 000 000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	238 370 900.00	236 428 391.36	1 942 508.64	99.19
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238 370 900.00	231 081 301.36	7 289 598.64	96.94
Орон нутгийн төсвөөс	238 370 900.00	231 081 301.36	7 289 598.64	96.94
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	5 347 090.00	(5 347 090.00)	#DIV/0!
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5 347 090.00	(5 347 090.00)	#DIV/0!
АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Төгрөгөөр/ Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>992 476 332.89</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>992 476 332.89</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	992 476 332.89
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	992 476 332.89
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	992 476 332.89
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1 000 506 652.89
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1 000 506 652.89
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	989 170 332.89
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11 336 320.00